

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/86/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2022.02.25 № УВА-2022/86/АА-ОГА
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200167

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	177,791,805.92	180,399,419.93
33	АВЛАГА	4,126,800.00	3,575,000.00
33510	Байгууллагаас авах авлага	4,126,800.00	3,575,000.00
34	УРЬДЧИЛГАА		7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	173,665,005.92	169,624,419.93
35100	Түүхий эд материал	114,562,585.52	99,437,499.53
35110	Тусгай зориулалттай материал	11,378,499.90	11,378,499.90
35130	Эм боох материал	103,184,085.62	88,058,999.63
35400	Хангамжийн материал	59,102,420.40	70,186,920.40
35410	Бичиг хэргийн материал	2,428,397.00	2,901,897.00
35420	Аж ахуйн материал	6,616,841.00	7,202,841.00
35430	Сэлбэг хэрэгсэл	80,000.00	80,000.00
35450	Барилгын засварын материал	27,116,000.00	27,116,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,861,182.40	32,886,182.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	449,153,688.72	348,073,830.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	449,153,688.72	348,073,830.84
39100	Газар	20,000,000.00	20,000,000.00
39200	Биет хөрөнгө	427,577,021.98	326,992,164.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,400,000.00	8,400,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(420,000.00)	(840,000.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,049,371.00	167,549,371.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,258,826.86)	(56,681,576.10)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	440,325,321.51	441,925,321.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(199,058,880.73)	(268,561,488.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,416,031.09	45,416,031.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,875,994.03)	(10,215,495.23)
39300	Биет бус хөрөнгө	21,576,666.74	21,081,666.74
39301	Програм хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(403,333.26)	(898,333.26)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	626,945,494.64	528,473,250.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	132,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	132,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	626,945,494.64	528,340,750.77
51	Засгийн газрын хувь оролцоо	626,945,494.64	528,340,750.77
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	626,945,494.64	528,340,750.77

51200	Хуримтлагдсан үр дүн	626,945,494.64	528,340,750.77
51210	Өмнөх үеийн үр дүн	626,945,494.64	626,945,494.64
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(98,604,743.87)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	626,945,494.64	528,473,250.77

2.2. АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,023,231,791.28	2,104,529,622.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	415,441,341.28	485,015,334.81
120	Нийтлэг татварын бус орлого	415,441,341.28	485,015,334.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	426,800.00	671,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	426,800.00	671,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	190,668,214.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	224,346,327.28	484,343,834.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,607,790,450.00	1,619,514,288.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	705,492,800.00	985,348,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	705,492,800.00	985,348,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	902,297,650.00	634,165,488.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	631,616,600.00	606,579,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,681,050.00	27,453,188.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	132,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,905,627,434.43	2,203,134,366.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,905,627,434.43	2,203,134,366.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,849,851,871.43	2,158,924,084.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,942,080.00	531,386,159.00
210101	Үндсэн цалин	438,729,852.00	362,709,553.00
210102	Нэмэгдэл	25,398,300.00	122,495,593.00
210103	Унаа хоол	2,813,928.00	41,753,513.00
210104	Урамшуулал	0.00	4,427,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,905,421.00	74,709,071.00
210201	Тэтгэврийн даатгал	53,762,736.00	50,890,132.00

210202	Тэтгэмжийн даатгал	5,668,756.00	5,378,785.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,002,705.00	3,591,513.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,133,711.00	4,228,871.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,337,513.00	10,619,770.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт		
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	54,454,493.00	45,623,490.00
210401	Бичиг хэрэг	13,114,900.00	8,399,200.00
210402	Тээвэр, шатахуун	27,837,771.00	27,351,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,126,372.00	4,045,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,185,800.00	418,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,189,650.00	5,409,500.00
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	450,368,331.01	696,192,283.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450,368,331.01	696,192,283.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,700.00	1,928,600.00
210604	Урсгал засвар	485,700.00	1,928,600.00
2107	Томилолт, зочны зардал	15,765,600.00	11,556,500.00
210702	Дотоод албан томилолт	15,765,600.00	11,556,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	692,864,470.00	691,578,223.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	691,567,960.00	686,911,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,253.00	304,273.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	190,582.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,065,776.42	105,949,757.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,269,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	93,065,776.42	102,679,857.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,775,563.00	44,210,282.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,749,154.00	7,080,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	6,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,749,154.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	580,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	117,604,356.85	(98,604,743.87)

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	117,604,356.85	(98,604,743.87)
----	--	----------------	-----------------

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,608,217,250.00	1,620,185,788.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	426,800.00	671,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	426,800.00	671,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	426,800.00	671,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	426,800.00	671,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,607,790,450.00	1,619,514,288.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	705,492,800.00	985,348,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	705,492,800.00	985,348,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	902,297,650.00	634,165,488.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	631,616,600.00	606,579,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,681,050.00	27,453,188.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	132,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,544,991,550.00	1,618,585,788.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,544,991,550.00	1,618,585,788.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,489,215,987.00	1,574,375,506.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,961,300.00	538,302,967.00
210101	Үндсэн цалин	77,323,000.00	335,094,167.00
210102	Нэмэгдэл	25,398,300.00	114,809,111.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,240,000.00	42,612,031.00
210104	Урамшуулал	0.00	4,427,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	41,360,158.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,304,700.00	67,792,263.00
210201	Тэтгэврийн даатгал	10,066,300.00	47,549,112.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,059,600.00	5,176,507.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	847,700.00	4,141,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	211,900.00	993,177.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,119,200.00	9,932,226.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,854,219.00	45,935,190.00
210401	Бичиг хэрэг	8,104,900.00	8,039,200.00
210402	Тээвэр, шатахуун	26,292,947.00	26,799,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,126,372.00	4,045,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,185,800.00	418,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,144,200.00	6,633,000.00

2105	Норматив зардал	173,835,150.00	207,156,863.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	169,821,350.00	197,385,863.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,013,800.00	9,771,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,751,700.00	4,986,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,250,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,501,700.00	4,986,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,893,000.00	11,424,000.00
210702	Дотоод албан томилолт	8,893,000.00	11,424,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,130,615,918.00	698,778,223.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,129,319,408.00	686,911,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,253.00	304,273.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	190,582.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,775,563.00	44,210,282.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,749,154.00	7,080,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	6,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,749,154.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	580,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	63,225,700.00	1,600,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	63,225,700.00	1,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,225,700.00	1,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,225,700.00	1,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,225,700.00	1,600,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-63,225,700.00	-1,600,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4. АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	0.00	0.00	509,341,137.79	509,341,137.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	509,341,137.79	509,341,137.79
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	117,604,356.85	117,604,356.85
10	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	626,945,494.64	626,945,494.64
11	2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	0.00	0.00	626,945,494.64	626,945,494.64
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	626,945,494.64	626,945,494.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-98,604,743.87	-98,604,743.87
20	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	528,340,750.77	528,340,750.77

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985,348,800.00	949,029,203.00	36,319,597.00	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,348,800.00	949,029,203.00	36,319,597.00	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	977,574,500.00	941,949,203.00	35,625,297.00	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,857,700.00	538,302,967.00	25,554,733.00	95.5
210101	Үндсэн цалин	340,199,500.00	335,094,167.00	5,105,333.00	98.5
210102	Нэмэгдэл	122,896,800.00	114,809,111.00	8,087,689.00	93.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,632,000.00	42,612,031.00	5,019,969.00	89.5
210104	Урамшуулал	4,427,500.00	4,427,500.00	0.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	48,701,900.00	41,360,158.00	7,341,742.00	84.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,485,100.00	67,792,263.00	8,692,837.00	88.6
210201	Тэтгэврийн даатгал	53,930,700.00	47,549,112.00	6,381,588.00	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,638,600.00	5,176,507.00	462,093.00	91.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,511,000.00	4,141,241.00	369,759.00	91.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,127,600.00	993,177.00	134,423.00	88.1
210205	Эрүүл мэндийн даатгал	11,277,200.00	9,932,226.00	1,344,974.00	88.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
210301	Гэрэл, цахилгаан				
210302	Түлш, халаалт				
210303	Цэвэр, бохир ус				
2104	Хангамж, бараа материалын зардал	31,149,000.00	31,147,600.00	1,400.00	100.0
210401	Бичиг хэрэг	6,039,200.00	6,039,200.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,512,800.00	16,512,100.00	700.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,045,100.00	4,045,100.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	418,200.00	418,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,133,700.00	4,133,000.00	700.00	100.0
2105	Нормативт зардал	7,149,500.00	7,149,250.00	250.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,978,500.00	6,978,250.00	250.00	100.0
210502	Хоол, хүнс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	171,000.00	171,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,600,000.00	3,600,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0

2107	Томилолт, зочны зардал	4,785,500.00	4,764,500.00	21,000.00	99.56
210702	Дотоод албан томилолт	4,785,500.00	4,764,500.00	21,000.00	99.56
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	290,547,700.00	289,192,623.00	1,355,077.00	65.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,805,400.00	277,326,350.00	479,050.00	49.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	430,000.00		100.00
210803	Даатгалын үйлчилгээ	482,000.00		482,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	346,300.00	304,273.00	42,027.00	87.86
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	306,400.00	132,000.00	174,400.00	43.08
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,813,600.00	10,800,000.00	13,600.00	99.87
210807	Газрын төлбөр	364,000.00	200,000.00	164,000.00	54.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,774,300.00	7,080,000.00	694,300.00	91.07
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,774,300.00	7,080,000.00	694,300.00	91.07
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,500,000.00	6,500,000.00		100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	687,900.00		687,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	586,400.00	580,000.00	6,400.00	98.91
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	985,348,800.00	949,029,203.00	36,319,597.00	96.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	985,348,800.00	949,029,203.00	36,319,597.00	96.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	985,348,800.00	949,029,203.00	36,319,597.00	96.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		634,026,303.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		634,026,303.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		634,026,303.00		
2104	Хангамж, бараа материалын зардал		14,787,590.00		
210401	Бичиг хэрэг		2,000,000.00		
210402	Тээвэр, шатахуун		10,287,590.00		

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,500,000.00		
2105	Нормативт зардал		200,007,613.00		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		190,407,613.00		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		9,600,000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,986,000.00		
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар		2,986,000.00		
2107	Томилолт, зочны зардал		6,659,500.00		
210702	Дотоод албан томилолт		6,659,500.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		409,585,600.00		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		409,585,600.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		634,026,303.00		
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		634,026,303.00		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		606,579,800.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		27,446,503.00		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, Мал амьтны эрүүл мэнд, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад төрийн бодлого хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд эрсдэлд суурилсан аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,622.5 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,203,134.3 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 11,015.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,512.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 528,473.2 мянган төгрөг буюу 15.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	4,126.8	3,575.0	-551.8
Бараа материал	173,665.0	169,627.4	-4,037.6
Үндсэн хөрөнгө	449,153.7	348,073.8	-101,079.9
Нийт хөрөнгө	626,945.4	528,473.2	-98,472.2
Өр төлбөр	0	132.5	132.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	626,945.4	528,340.7	-98,604.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	626,945.4	528,473.2	-98,472.2

Авлага дансны үлдэгдэл 3,575.0 мянган төгрөг болж 551.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 169,627.4 мянган төгрөг болж 4,037.6 төгрөгөөр буурсан нь эм вакцин, ариутгалын бодисын үлдэгдлийг зарцуулсантайгаар холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 528,473.2 мянган төгрөг болж 101,079.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 102,679.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, шинээр 1,600.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 40,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийг тогтоолоор акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 528,340.7 мянган төгрөг болж 98,604.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 81,298.0 мянган төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 2,203,134.3 мянган төгрөг буюу 16.0 хувиар өссөн байна. Үүнд үндсэн хөрөнгийн элэгдэл, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлууд байна.

Тайлант онд 132.5 мянган төгрөгийн албан томилолтын өр төлбөр үүссэн байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,096,670.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,096,670.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 111,323.1 мянган төгрөгөөр бууруулж 985,348.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 985,348.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 985,348.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 949,029.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 949,029.2 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвийн санхүүжилтээр малын вакцины үнэ үйлчилгээний хөлс, малын өвчний лабораторийн судалгаа шинжилгээ, тандалтын үйл ажиллагааны хүрээнд 634,026.3 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 24,433.6 мянга, норматив зардалд 200,007.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 409,585.6 мянга, нийт 634,026.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Мал эмнэлгийн газар хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 150, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгснийг Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 47/37 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 702 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн газрын хөрөнгө актлах, дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл ирсний дагуу дуудлага худалдааг зохион байгуулсан байна. Уг асуудал хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 02-ны А-13 дугаар тушаалаар жолооч /сантехникч/ нэг орон тоо баталсан байхад гүйцэтгэлээр хоёр жолооч ажиллуулсан алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

4.4 Зөвлөмж

1. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг зөрчин нэг орон тоон дээр хоёр ажилтан ажиллуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж заагдсан орон тоог хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Мал эмнэлгийн газар	1									1	
	ДҮН	1									1	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТ-СУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр